



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Ажлын байрны төлбөрөөс
хөнгөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.3.5, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1776, 01/1779, 01/1780, 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1843, Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 04/2581, 04/2656, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 10/3124, 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10/3186, Эрчим хүчний яамны 06 дугаар сарын 13-ны өдрийн в/2345, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн в/2369, Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 3/2901, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 08/836 тоот албан бичгүүдээр ирүүлсэн санал, “Ажлын хэсэг байгуулах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/105 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн хавсралтад заасан 14 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 827 гадаад ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 50 хувиар хөнгөлсүгэй.

2. Хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын урьдчилж төлсөн 2022 оны ажлын байрны төлбөрийн зөрүүг дараагийн төлбөрт шилжүүлэн тооцох, буцаан олгох арга хэмжээ авахыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашбэмбэрэл/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т даалгасугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201617

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2022 оны 06 сарын 22 өдрийн
А/126 дугаар тушаалын хавсралт

**АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨРӨӨС ХӨНГӨЛӨХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАДААДЫН АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТОО**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон эрх зүйн баримт бичиг	Асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал
Нэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулах					
1	“БОЛОРНЯМХҮҮ” ХХК	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт цайны газрын үйлчилгээ эрхлэх	3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 6/745 тоот албан бичиг	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1776 тоот албан бичиг
2	“Нандинням” ХХК	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт цайны газрын үйлчилгээ эрхлэх	2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10/3667 тоот албан бичиг	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1779 тоот албан бичиг
3	“Нандинхүү” ХХК	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт зоогийн газрын үйлчилгээ эрхлэх	7	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 10/3438 тоот албан бичиг	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 01/1780 тоот албан бичиг

4	“Монгол нью ресурс технологи” ХХК	Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт малын ясыг боловсруулж, техникийн тос, бордоо үйлдвэрлэх	3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 6/1651 тоот албан бичиг	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1843 тоот албан бичиг
Нийт			15		
Хоёр. Барилгын салбарт үйл ажиллагаа явуулах					
5	“Өршөөлтийн ариун” ХХК	Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт музейн барилгын дотор чимэглэлийн ажил гүйцэтгэх	1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 6/137 тоот албан бичиг	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 3/2901 тоот албан бичиг
6	“Хэ Шин” ХХК	Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хаягдал төмөр хайлуулан ган туйвангийн үйлдвэрлэл явуулах	40	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 3/2901 тоот албан бичиг
7	“Дархан анд” ХХК	Налайх дүүргийн нутаг дэвсгэрт ган туйвангийн үйлдвэрлэл явуулах	40	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай”	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 3/2901 тоот албан бичиг

				Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	
Нийт			81		
Гурав. Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулах					
8	"ТВЕА" ХХК	Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх төсөл гүйцэтгэх	720	"Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	Эрчим хүчний яамны 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн в/2345 тоот албан бичиг
9	"Укрэлектромонтаж" ХХК	Эрчим хүчний барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх	2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10/3338 тоот албан бичиг	Эрчим хүчний яамны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн в/2369 тоот албан бичиг
Нийт			722		
Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулах					
10	"ЕСКК" ХХК	Массажист чиглэлээр үйл ажиллагаа явуулах	1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 6/295 тоот албан бичиг	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 10/3124 тоот албан бичиг

11	“Хаан Палас” ХХК	Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулах	1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 6/2168 тоот албан бичиг	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10/3186 тоот албан бичиг
Нийт			2		
Тав. Мэдээлэл, харилцаа, холбооны салбарт үйл ажиллагаа явуулах					
12	“Спин А Вэб” ХХК	Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулах	1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 6/1877 тоот албан бичиг	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 08/836 тоот албан бичиг
Нийт			1		
Зургаа. Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулах					
13	“Мотор сервис” ХХК	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 240км хүнд даацын хатуу хучилттай авто замын төсөлд ажиллах	2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 6/1951 тоот албан бичиг	Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 04/2656 тоот албан бичиг
14	“Бодиз автомобил” ХХК	Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулах	4	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн	Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 04/2581 тоот албан бичиг

		6/1285 тоот албан бичиг
Нийт		6
НИЙТ		827

---oOo---